



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 5/02

Чингис хот

Б.Онончимэгийг ажлаас чөлөөлж,
ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 274 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” 277 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.5, 1.6, 2.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Баярсайханы Онончимэгийг ажлын зайлшгүй шаардлагын улмаас тус хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд шилжүүлэн ажиллуулах болсон тул 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд Б.Онончимэгийг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилон ажиллуулсугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн

Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын
санхүүжилт хариуцсан мэргэжилтэн

Т.Бямбадулам

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Нярав

4. Б.Онончимэгийн цалинг ТЗ-5-5 шатлалаар тогтоон үндсэн цалин 732900 /долоон зуун гучин хоёр мянга есөн зуу/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10,

2.

зэрэг дэвийн нэмэгдлийг 18 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-
д зөвшөөрсүгэй.

5. Дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод
заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Онончимэгт үүрэг
болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР